

МОНГОЛ ОРНЫ МӨЛГӨР ЦОХЫН (*Buprestidae*)

ИДЭШ ТЭЖЭЭЛ, ТАРХАЛТ

Б. Батчөдөр¹, Д. Ганбат². ШУА, Геоэкологийн хүрээлэн,
b_batchudur@yahoo.com, dgambii@yahoo.com

Хураангуй

Манай орны шавжийн бие бүтэц, ангилал, тархалт байршил, гарал үүсэл, түүхэн хөгжлийн онцлогийг судлан тогтооход гадаад улс орны эрдэмтэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн билээ. Алексеев А. В, Волкович М. Г нарын бүтээл болон бусад судлаачдын материалуудыг шүүн нэгтгэж зүйлийн бүрэлдэхүүн, идэш тэжээл, тархалтыг гаргалаа. Мөлгөр цохын бүрэлдэхүүний хувьд авч үзэхэд нийт 104 зүйлийн цох тархсан бөгөөд дийлэнх хувийг *Agrilus*, *Sphenoptera* төрлүүд эзэлж байна. Энэ төрлийн цохууд полифаг идэштэй, ямарч амьдрах орчинд амьдрах чадвартайг харуулж байна. Нарс, шинэс модонд *Melonyphila cyanea* Fabr, *M. guttulata* Gebl, *Anthaxia quadripunctata* L, *Chrysobothris chrysostigma* L, жимс жимсгэний ургамалд *Lampra limbata* Mannh, хадлан бэлчээрийн ургамалд *Sphenoptera potanini* Jac, *S. canaliculata* Pall зэрэг зүйлүүд нилээд хөнөөл учруулдаг. Биогеографийн тархалтаас авч үзэхэд Скифийн хээрийн бүсэд нийт зүйлийн 35 хувь тархалттай бөгөөд энэ бүсэд хамаарах Дорнод Скифийн *Sphenoptera sajanensis* Obenb, *S. ubarchangajensis* Cobos, *S. sulcata mongoliana* Cobos, *S. altaica* Cobos, *S. cobosi* Alex, *Aphanisticus kaszhavi* Cobos, *Agrilus plavilstshikovi* Alex, *A. pseudolimoniastri* Cobos, *A. spessivcevi* Obenb зэрэг 9 эндемик зүйлүүд тэмдэглэгдсэн байна [1], [2].

Түлхүүр үг: Мөлгөр цохын бүрэлдэхүүн, судлагдсан байдал, хооллолт, биогеографийн тархалт.

Оршил

Манай оронд тархсан мөлгөр цохын (*Buprestidae*) зүйлийн бүрдэл, тархалт, идэш тэжээлийн судалгааг А.В. Алексеев, М.Г. Волкович (1989), Кобос, Г. Похон нар судалж, 80 гаруй зүйлийн мөлгөр цохын илрүүлсний дотор 32 зүйлийг шинжлэх ухаанд шинээр нээсэн байдаг [3]. Түүнээс хойш мөлгөр цохын овгийн дагнасан судалгаа төдийлөн сайн хийгдээгүй байна.

Дэлхий дээр 700 гаруй мөлгөр цох бүртгэгдсэний дотор Орос улсын нутагт 400 гаруй зүйл тэмдэглэгджээ. Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны Улаан дансанд бүртгэгдсэн устах аюулд орсон 1 зүйлийн мөлгөр цох бүртгэгдсэн ба одоогийн байдлаар манай оронд тэмдэглэгдээгүй байна. Мөлгөр цох нь гол төлөв түймэр, мод бэлтгэл явагдсан, унасан мод мөчир, хожуулд, навч шилмүүсээр хооллогч шавжинд нэрвэгдсэн ойд олширч хөнөөлийн голомт үүсгэдэг. Мөн түүнээс гадна мөлгөр цохууд ойн экосистемийн үйл ажиллагаанд, ялангуяа доройтож, хэвийн үйл ажиллагаагаа алдсан модны хаталт, ялзрал, өмхөрлийн процессыг улам эрчимжүүлж, хөрс үүсэх, шим бодис бүрэлдэх, бодисын эргэлтийг хурдасгахад чухал нөлөө үзүүлэх байгалийн томоохон хүчин зүйлд зүй ёсоор ордог [4].

Судалгааны аргазүй

А. В Алексеев, М. Г Волкович, В. Яновский, А. Цэндсүрэн, Д. Тэгшжаргал нарын бүтээл болон бусад судлаачдын материалуудыг шүүн нэгтгэсний дүнд манай оронд тархсан мөлгөр цохын зүйлийн бүрэлдэхүүн, идэш тэжээл, тархалтыг нэгтгэн үзүүллээ [1], [2], [3],[5], [6] [7].

Үр дүн

Судалгааны материалуудад үндэслэн шүүн нэгтгэсний дүнд манай орны нутаг дэвсгэрт нийт 104 зүйлийн мөлгөр цох тархсан байна [1], [2]. Мөлгөр цохын бүрэлдэхүүний хувьд авч үзэхэд дийлэнх хувийг *Agrilus*, *Sphenoptera* төрлийн цохууд эзэлж байна. График 1-с харахад *Agrilus* төрлийн цохууд хамгийн олон зүйлтэй байгаа нь энэ төрлийн цохууд полифаг идэштэй, ямарч амьдрах орчинд амьдрах чадвартайг харуулж байна.



График. 1. Мөлгөр цохын төрлүүд

Нарс, шинэсэнд *Melonyphila cyanea* Fabr, *M. guttulata* Gebl, *Anthaxia quadripunctata* L, *Chrysobothris chrysostigma* L, жимс жимсгэний ургамалд *Lampra limbata* Mannh, хадлан бэлчээрийн ургамалд *Sphenoptera potanini* Jac, *S. canaliculata* Pall зэрэг зүйлүүд нилээд хөнөөл учруулдаг.

Манай орны ойд 35 зүйлийн мөлгөр цох тархсан (4) бөгөөд авгалдайн үедээ мод сөөг, өвс, ургамлын навч шилмүүс, иш холтос, үндэс, үр жимс, цэцэг зэрэг ургамлын янз бүрийн эд, эрхтэнээр хооллоно. Шүүсэн материалуудаас идэш тэжээлийн хувьд мэдэгдэж байгаа зүйлүүдээс авч үзэхэд 37% нь навчит модоор, 22 % нь өвслөг ургамлаар, 21% бут, сөөгөөр, 20% шилмүүст модоор тус тус хооллож байна. Эндээс харахад модлог ургамлаар хооллогч шавжууд зонхилж байгаа нь цохын өсөлт бойжил нь холтосон доор эсвэл, модлог эдийн дотор явагдаж, ойн баялаг түүний нөөцөд хөнөөл учруулдаг болох харагдаж байна.




График. 2. Мөлгөр цохын идэш тэжээл

Манай оронд тэмдэглэгдсэн мөлгөр цохын овгийн шавжийн тархалтыг нэгтгэн 3-р графикт харуулав. Мөлгөр цохын ихэнх хувь нь (13%) буюу 55 зүйл манай орны Төв аймгийн нутгаар тархжээ. Харин Завхан, Баян-Өлгий (1-2 хувь) зэрэг баруун аймгуудын зарим нутгаар ядмаг зүйлтэй (3-8 зүйл) байгаа нь нэг талаас амьдрах орчны сонголт, нөгөө талаас судалгааны мэдээ баримт дутмаг хийгдсэнтэй холбоотой байж болох юм. *Sphenoptera densesculpta* Jakovleff 1908, *Agrillus ecarinatus* Marseul 1865, *Agrillus pseudolimoniastri* Cobos 1968, *Anthaxia quadripunctata* Linnaeus 1758, *Sphenoptera canaliculata* Pallas 1781, *Sphenoptera extensocarinata* Jakovleff 1889 зүйлүүд ихэнх аймгуудад тархсан байгаа нь эдгээр зүйлийн цохуудын элбэгшил их, тархалтын хүрээ харьцангуй өргөн байдагтай холбон тайлбарлаж болох юм.




График. 3. Мөлгөр цохын аймгуудаар тархсан байдал

Монгол оронд тархсан мөлгөр цохын овгийг Кобос (1972) зоогеографийн мужлалаар нь Төв Азийн ба Европ Сибирийн гэсэн хоёр хэсэгт хуваасан. Дараа нь Алексеев, Волкович (1684), Емельянов, (1974) нар биогеографийн мужлалаар нь Европ Сибирийн тайгын, Стенопейн немораль, Скифийн хээр, Сетийн цөлийн гэсэн 4 бүс бүслүүрт ангилсан байна [1].




График. 4. Мөлгөр цохын биогеографийн тархалт

Мөлгөр цохын зүйлүүдийг биогеографийн (*ургамал, амьтны газарзүйн тархалт*) тархалтаас авч үзэхэд Скифийн хээрийн бүсэд нийт зүйлийн 35 хувь тархалттай бөгөөд энэ бүсэд хамаарах Дорнод Скифийн *Sphenoptera sajanensis* Obenb, *S. ubarchangajensis* Cobos, *S. sulcata mongoliana* Cobos, *S. altaica* Cobos, *S. cobosi* Alex, *Aphanisticus kaszhavi* Cobos, *Agrilus plavilstshikovi* Alex, *A. pseudolimoniastri* Cobos, *A. spessivcevi* Obenb зэрэг 9 эндемик зүйлүүд тэмдэглэгдсэн байна [1], [2]. Эдгээр зүйлүүд нь манай орны аймгуудаар харилцан адилгүй тархаж, *Sphenoptera sajanensis* Obenb, *Sphenoptera cobosi* Alex, *Agrilus plavilstshikovi* Alex зүйлүүд нь Монгол орны хэмжээнд маш ховор тархалттай тул Монголын улаан номонд оруулах боломжтой юм. Харин Европ Сибирийн тайгын бүсэд 28 хувь илэрч, энэ бүсэд Дагуур Манжуурын, Өмнөд Зайбайкаль, Зүүн өмнөд Хятадын тархалттай зүйлүүд хамаарагдаж байна. Сетийн цөлийн бүсэд 22 хувь, Стенопейн немораль бүсэд 15% нь тархалттай байна.

Дүгнэлт

Судалгааны материалуудын нэгтгэсэн дүнгээр манай орны нутаг дэвсгэрт нийт 104 зүйлийн мөлгөр цох тархжээ.

Мөлгөр цохын овгийн зарим зүйл ихэнх аймгуудад түгээмэл тархсан байгаа нь эдгээр зүйлүүд экологийн хувьд уяан хатан шинжтэй, янз бүрийн амьдрах орчнуудад амьдрах чадвартайг илтгэж байна

Идэш тэжээлийн хувьд модлогоор хооллогч мөлгөр цохууд давамгайлж байгаа нь амьдрах чадвараа алдсан моднууд шавжийн хувьд их хэмжээний илүүдэл тэжээл болдог төдийгүй ойн экосистемийн тэнцвэрт байдлаас ихээхэн шалтгаалдаг болох нь харагдаж байна.

Мөлгөр цохын зүйлүүд амьдрах орчны төлөв байдлыг сайн илтгэх төдийгүй, ялангуяа ой модны өөрчлөлт хувиралтанд хариу үзүүлдэг. Өөрөөр хэлбэл биоиндикатор болгон ашиглах боломжтой.

Иш татсан ном, зохиолын нэрс

- [1], Алексеев А. В, Волкович М. Г 1984. Обзор жуков-златок (Coleoptera, Vuprestidae) Монгольской народной республики 10: Насекомые Монголии с. 301-368
- [2], Алексеев А. В, 1975. Фауне жуков-златок Монгольской народной республики 3: Насекомые Монголии.
- [3]. Цэндсүрэн А. 1987. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Амьтны аймаг: Шавжийн анги 1 боть х. 93-94
- [4]. Marco Moretti, Sylvie Barbalat, 2004. The effect of wildfires on wood-eating beetles in deciduous forests on the southern slope of the Swiss Alps., Forest Ecology and Management 187 (2004) 85–103

- [5]. Яновский В. М. 1977. Насекомые-Дендрофаги Монголии. Монгольской народной республики. Вып. 5, Насекомые Монголии. С.30-57
- [6]. Яновский В. М, 1974. Особенности размещения фауны жестокрылых ксилофагов (Coleoptera) в лесах северной Монголии. Энтомологическое обозрение, ЛШ, 4, 1974. с- 772
- [7]. Тэгшжаргал Д, 2009. Монгол орны ойн шавжийн бүрэлдэхүүний асуудалд Монгол орны Геоэкологийн асуудал. х. 54-58